

Тэгш байдал

*Дэлхийн хүн амын өдөрт зориулан
Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамнаас бэлтгэв.*

Дэлхийн хүн амын өдөр нь энэ жил “Тэгш байдал” уриан дор болж байна. Жил бүр уламжлал болгон тэмдэглэдэг энэхүү өдөр нь долоодугаар сарын 11-нд буюу Улс хувьсгалын их баяр наадмын өдөр болдгоороо манай орны хувьд онцлог юм.

Тэгш байдал хүн бүрт эрх мэдэл, боломж олгодог. Тэгш байдал гэдэг бол эмэгтэйчүүд эдийн засгийн боломжийг тэгш хүртэж, ядуу өрх, гэр бүл эхчүүд, эмэгтэйчүүдийн дэмжлэгт тулгуурлан амьдралаа залгуулах боломж юм. Мөн эмэгтэйчүүд улс төр, шийдвэр гаргах үйл явцад оролцох бүрэн эрхтэй байхыг хэлнэ.

Дэлхийн болон үндэсний хэмжээнд хүний эрх, хүний хөгжлийн талаар явагдсан уулзалт, хурлуудаар жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдэд тэгш эрх олгох асуудлын ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн байна. Хөгжиж буй олон оронд эмэгтэйчүүдийн эрхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. Тэд хүн ам ба хөгжлийн бодлогоо шинэчлэн боловсруулж, НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээг сайжруулах, жендэрийн тэгш бус байдлаас үүссэн хүчирхийллийг арилгах, ХДХВ-ын халдвараас урьдчилан сэргийлэх, улс төрд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг зогсооход чиглэсэн өргөн хүрээтэй үйл ажиллагааг явуулж байна. Жендэрийн ялгаанаас үүдэлтэй эрх мэдлийн тэнцвэргүй харьцааг өөрчлөх үйл хэрэгт эрэгтэйчүүд улам бүр ухамсартай, хариуцлагатай, идэвхтэй хандаж байна.

НҮБ-ын Хүн амын сан тэгш байдлыг олон хэлбэрээр дэмжин хэрэгжүүлдэг. Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурал (ХАХОУБХ)-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж буй газруудад үйл явц амжилттай өрнөж байна. Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулах, залуучуудад хүрч ажиллах, ХДХВ-ын халдвараас урьдчилан сэргийлэх, эхчүүдийн эсэн мэнд амаржих ахуй нөхцөлийг хангах зэрэгт НҮБ-ын Хүн амын сангийн үйл ажиллагаа илүүтэй чиглэгдэж байна. Энэ бүхэн нь охид, эмэгтэйчүүдийн эрүүл энх аж төрөх боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд нөлөө үзүүлж, сайн сайхан амьдрах бололцоог нэмэгдүүлдэг байна. *Тухайлбал:*

- *Тэгш байдал бол эмэгтэйчүүдийн эрхийн асуудал төдийгүй хүн бүхний ахуй амьдралыг сайжруулах боломжийг өргөжүүлдэг.*
- *Тэгш байдлыг сайжруулах чиглэлээр бодитой ахиц дэвшил гарсаар байна.*
- *Тэгш байдал ядуурлыг арилгахад нөлөөлдөг.*

Тэгш байдал нь хөгжлийн эн тэргүүний зорилтын нэг юм. Хүн ам ба хөгжлийн олон улсын бага хурлын үйл ажиллагааны хөтөлбөр, Бээжингийн бага хурлын үйл ажиллагааны хөтөлбөр, Мянганы хөгжлийн зорилтууд бол хөгжлийн төлөө нэг нь нөгөөгөө харилцан дэмжсэн үйл явц бөгөөд эмэгтэйчүүдийн эрхийг онцгойлон хүндэтгэж, улмаар дэлхий дахины хэмжээнд тулгамдаж буй аливаа асуудлыг шийдвэрлэхэд эмэгтэйчүүдийн эрх мэдэл, бүрэн тэгш оролцоо нэн чухал шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн билээ. Эмэгтэйчүүдийг ялгаварлан

гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенци бол эмэгтэйчүүдийн эрх мэдэл, тэгш эрхийг хангах чухал баримт бичгийн нэг юм.

Дэлхийн 180 шахам орны Засгийн газрууд Кайр хотноо 1994 онд хуралдсан Хүн ам ба хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурлаар жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, тэдний эсрэг үйлдэгдэж буй бүх төрлийн хүчирхийллийг устгах, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэх зэрэг зарчмуудыг хүн ам ба хөгжлийн холбогдолтой хөтөлбөр, төслүүдэд баримталж байхаар санал нэгтэй тохиролцсон байна.

Шигтгээ:

“Охид, эмэгтэйчүүд бүх эн хаана төрсөн, хаана амьдарч байгаа эсэхээс үл хамааран тэгш боломжийг хүртэж, дэлхий нийт ээр хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг эдлэх эрхтэй, үнэ цэнэтэй хүмүүс юм. Жендэрийн тэгш байдлыг олон улсын энх тайвны хөгжлийн төлөө үйл ажиллагааны эн тэргүүнд тавих хүчин чармайлтыг эрчимжүүлэх цаг нь одоо болжээ”

*НҮБ-ын Хүн амын сангийн Гүйцэтгэх захирал Торай Обайдын
2005 онд Олон улсын эмэгтэйчүүдийн өдөрт зориулан хэлсэн үгнээс*

Тэгш байдал ядуурлыг арилгахад нөлөөлдөг. Тэгш байдал хүний хөгжилд маш чухал үүрэгтэй. Тийм ч учраас Мянганы хөгжлийн зорилтын 3 дахь хэсэг нь “жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, тэднийг чадавхижуулах”-д чиглэгдсэн. Жендэрийн тэгш байдлыг хангах явдал Мянганы хөгжлийн зорилт, түүнчлэн Хүн ам ба хөгжлийн асуудлаарх олон улсын бага хурлаар баталсан үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн зайлшгүй чухал нөхцөл юм. Тэгш байдал өөрөө эдийн засгийн нөөцийг хуваарилах, боловсрол, НҮЭМ-ийн салбарт хөрөнгө оруулах үйл ажиллагаатай шууд холбоотой байдаг. Эдгээрийн үр дүнд ядуурлыг устгах, улмаар хөгжилд хүрэх үйл явцад асар их түлхэц өгөх боломж олгодог.

Жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр анхаарал төвлөрүүлбэл зохих үйл ажиллагааны хүрээ

Боловсрол: Эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах, багш, сурган хүмүүжүүлэгч нарын жендэрийн мэдрэмжийг ахиулах, охид, хөвгүүдэд адил боловсрол олгохын нийгмийн үнэ цэнийг ойлгуулах, тэдэнд эрт гэр бүл болох, хүүхэд төрүүлэхийн хор холбогдлыг ухааруулах, жирэмсэлсэн өсвөр насны охидыг сургуульд үргэлжлүүлэн суралцах эрхийг хүлээн зөвшөөрөх, НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй хүргэх, улмаар хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн ерөнхий түвшинг бууруулах ажлыг тасралтгүй зохион байгуулах замаар бүх охид, хөвгүүдийг суурь боловсролтой болгох зорилгыг хэрэгжүүлэх боломжтой юм.

Эдийн засгийн боломж, бололцоо: Хөдөлмөр эрхлэлтийн болон эдийн засгийн үйл ажиллагааны салбарт эмэгтэйчүүдийг адил тэгш эрхтэйгээр оролцуулахад хүндрэл учруулж буй саад бэрхшээлийг арилгаж чадсанаар тэдэнд илүү орлого олох бололцоо нээлттэй болох төдийгүй өөрт нь, гэр бүлд нь, улмаар улс эх оронд нь ашиг тус өгдөг байна. Төрөлтийг ухамсартайгаар төлөвлөж, төрөлт хоорондын зайг зохицуулж чадсан тохиолдолд эмэгтэйчүүдэд эдийн засгийн үйл ажиллагаанд илүү сайн оролцох боломж нээгддэг. Охид, эмэгтэйчүүд газар, зээл зэрэг хөрөнгө

нөөц ашиглах, мөн дээд шатны боловсрол, албан ёсны хөдөлмөр эрхлэлтэд хамрагдах боломж бүрдсэн үед эдийн засгийн үр ашиг нэмэгддэг байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрх: Нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрх нь хүүхдийн тоо, төрөлт хоорондын зайг өөрөө шийдэх эрх зэрэгтэй холбоотой ойлголт юм. НҮЭМ ба эрх нь эмэгтэйчүүдийн тэгш эрх болон жендэрийн тэгш байдлыг хангах, тэдний боловсрол эзэмших, эрүүл мэндээ хамгаалуулах, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын үйл хэрэгт бүрэн тэгш оролцох зэрэг хүний эрхийг хангахад чиглэсэн гол үүрэг гүйцэтгэдэг.

НҮЭМ-ийн бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, түүнээс урьдчилэн сэргийлэх боломжтой боловч тухайн хувь хүний эрүүл мэнд, амьдралын чанар, бүтээлч байдал нь эмэгтэйчүүдийн тэгш эрхэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг ажээ. Жирэмслэлт болон төрөлтөөс үүдсэн нас баралтын өндөр хувь хэмжээ, эмэгтэйчүүдийн эрх ашигт харш зан заншил зэрэг үйл явдал тэгш бус байдалтай ихээхэн холбоотой байдаг. Эмэгтэйчүүд эрсдэлтэй бэлгийн хавьтлаас татгалзах, аюул багатай бэлгийн хавьтлыг зөвшилцөх эрх мэдэл, хүчин мөхөс, соёлын түвшин доогуур газар нутагт тэгш бус байдал амь бөхтэй оршиж, ХДХВ/ДОХ-ын халдварын тархалт эрчимжиж байна. Охидууд эрт гэрлэж, хүүхэд төрүүлснээр боловсрол эзэмших үйл хэрэг оройтож, нөөц бололцоо хязгаарлагдаж, эрүүл мэндээр хохирох ноцтой эрсдэлд орох нөхцөл бүрддэг байна.

Эмэгтэйчүүдийн оролцоо: Улс төрийн хүрээнд эмэгтэйчүүдийн оролцооны түвшин жендэрийн тэгш байдлын үндсэн суурь үзүүлэлт болдог. Эмэгтэйчүүдийн оролцоог нийгэмд нэмэгдүүлэхэд олон шалтгаан нөлөөлдөг. Тухайлбал, хөгжлийн төлөө хэлэлцүүлэг, хүчин чармайлтыг амжилтад хүргэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үзэл бодлыг нэг адил тусгах ёстой. Улс төрийн болон хөгжлийн тодорхой шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн идэвхтэй оролцоог дэмжих явдал маш чухал. Жендэрээр ялгаварласан хүчирхийлэл эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог хязгаарлаж, тэдний өв тэгш хөгжилд хүрэх үйл явцад саад учруулж байна.

Мэдээллийн зарим үзүүлэлт

- Гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгслийн хэрэглээ, үйлчилгээний хүртээмж улам бүр нэмэгдэж байна. Хөгжиж буй орнуудад 1960 онд нийт гэрлэгсдийн 10-15 хувь нь жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгсэл хэрэглэдэг байсан бол өнөөдөр 60 хувь нь хэрэглэдэг болжээ.
- Гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгсэл, үйлчилгээний хүртээмжийг баталгаатай болгосноор эхийн эндэгдлийг 25 хувь, хүүхдийн эндэгдлийг 20 хүртэл хувь бууруулах боломжтой гэж тооцоолсон байна. Төрөлтийн үйл явцыг ур чадвартай эх баригч, эмнэлгийн эмч, мэргэжилтэн удирдсанаар эхийн нас баралтыг 74 хувиар бууруулах боломжтой гэж үздэг байна.
- Дэлхийн хүн ам 6,5 тэрбумд хүрсэн өнөө үед хүүхэд төрүүлэх насанд шилжиж байгаа охидын тоо түүхэнд урьд хожид байгаагүй тоо хэмжээнд хүрч, тэдний олонхи нь хөгжиж буй орнуудад ядуу зүдүү амьдралын орчин, нөхцөлд төрж өссөн байна.
- Дэлхийд өдөр бүр 70 гаруй мянган өсвөр насны охид нөхөрт гарч, 40 орчим мянган охид хүүхэд төрүүлж байна.
- Африкийн Сахарын өмнөд нутгуудад, ХДХВ-ын халдвар авах эрсдэл 15-24 насны охидын хувьд эрчүүдтэй харьцуулбал 3-4 дахин өндөр байна.

- НҮБ-ын Хүүхдийн сангийн мэдээллээр дэлхийд сургууль завсардсан 121 сая хүүхдийн 65 сая нь буюу 54 хувь нь охидууд байна.
- Дэлхийд бичиг үсэг мэдэхгүй нийт 600,000 эмэгтэй, 320,000 эрэгтэй хүн ам байгаа бөгөөд бичиг үсэг мэдэхгүй эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдийнхээс бараг 2 дахин олон байна.
- Дэлхийд нийт эмэгтэйчүүдийн гуравны нэг нь зодуулах, хүчинд автаж бэлгийн харьцаанд орох, эсвэл өөр ямар нэг байдлаар хүчирхийлэлд өртөж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь ихэвчлэн тэдний нөхөр юм уу, эсвэл гэр бүлийн гишүүн зэрэг ойр дотны эрчүүд байдаг аж. Дөрвөн эмэгтэй тутмын нэг нь жирэмсэн байхдаа хүчирхийлэлд өртөж байжээ.
- Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хангах явдал стратегийн эн тэргүүний ач холбогдолтой алсын бодлого юм. Улс төрийн албан тушаал дахь эмэгтэйчүүдийн оролцоо 30 хувиас бага байдаг улс орнуудад жендэрийн тэгш байдлыг хангахад ардчилал, хүний эрх, олон нийтийн оролцоо зэрэг нь сул хөгжсөн байдаг ажээ.

НҮБ-ын ХАС-гийн дэмжлэгтэйгээр тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа

Зарим улс орны жишээнээс

Энэтхэг: НҮБ-ын ХАС тус улсын үндэсний болон орон нутгийн ТББ-уудтай хамтран ажиллаж, нийт хүн амынх нь хүйсийн харьцаанд өсөн нэмэгдсээр буй ялгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил тод сурталчилж, энэ асуудлыг судлан үзэх сонирхол бий болгосон байна. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын хүрээнд ухуулга хийхэд нь дэмжлэг үзүүлж, орон нутгийн бүлгүүдтэй хүн амын хандлагыг өөрчлөх ажил хамтран зохион байгуулжээ.

Хятад: Хүйсийн тэнцвэргүй байдлыг олон нийтэд сурталчлан таниулах Бүх Хятадын эмэгтэйчүүдийн холбооны ажилд дэмжлэг үзүүлж, 13 нутагт ядуусын хорооллын эмэгтэй хүүхдүүдийг дэмжих төсөл хэрэгжүүлэхэд нь тусалсан байна.

Боливи: Тус улсын 35 мужид НҮБ-ын ХАС-гийн дэмжлэгтэйгээр НҮЭМ-ийн боловсрол олгоход чиглэсэн төсөл хэрэгжүүлж, хүн амыг нь бичиг үсэгт сургаж, мөнкүшуа, испани хэлний мэдлэгийг нь дээшлүүлжээ. Энэхүү төсөл нь дэвшилтэт үзэл санаа бүхий жендэрийн болон соёлын мэдрэмжтэй хөтөлбөр боловсруулснаараа ЮНЕСКО-гийн шагнал хүртсэн юм.

Вьетнам: Тус улсын умард зүгийн хөдөө аж ахуй эрхэлдэг тосгоны хүн амын дунд бичил зээл, хадгаламжийг НҮЭМ-ийн тусламж үйлчилгээтэй хослуулсан төсөл хэрэгжүүлж байна. Вьетнамын эмэгтэйчүүдийн холбооноос эрхлэн гүйцэтгэж буй энэ төсөл нь эмэгтэйчүүдэд зээл олгож, нөөц бололцоог нь хянах боломж олгож, НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгосноор ядуу айл өрхүүдийг ядуурлаас ангижруулах зорилготой ажээ. Бүлгийн 30 гаруй гишүүний өрхийн орлого хоёр жилийн дотор хоёр дахин өссөн байна.

Латин Америк, Кариб: Энэ бүс нутгийн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн сүлжээ нь үндэсний хэмжээнд Хүн ам ба хөгжлийн асуудлаарх Олон улсын бага хурлын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг санаачилгадаа авч, сүүлийн арав гаруй жилийн турш хэрэгжүүлж иржээ. Эмэгтэйчүүдийн бүлгүүд холбогдох тоо баримтад дүн шинжилгээ хийж, парламентын гишүүд хууль зүйн салбарт

шинэчлэл хийхийг хөхиүлэн дэмжихдээ тэдгээрээс иш татаж, НҮБ-ын бага хурлын төлөөлөгчид хуралд оролцохдоо, Суринамын бодлого төлөвлөгчид ажилдаа ашигладаг болсон байна. Чили, Никарагуа, Перу болон Суринамд тэрхүү дүн шинжилгээ нь Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн талаархи бие даасан илтгэлүүдийн үндэс нь болж өгдөг байна.

Габоны Либрэвилльд 2004 оны арваннэгдүгээр сард НҮБ-ын Эмэгтэйчүүдийн сантай хамтран Африкийн эмэгтэй сайд, парламентын гишүүдийн сүлжээний бүс нутгийн зургадугаар бага хурал зохион байгуулжээ. Тус бага хурал Африкийн өмнөд нутаг дахь орнуудын парламентын эмэгтэй гишүүд, сайд нарт жендэрээр ялгаварласан хүчирхийллийн тухай мэдээлэл авах боломж олгосон байна. Тэд жендэрээр ялгаварласан хүчирхийлэлтэй тэмцэх нь Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх нэг гол алхам хэмээн үзэж, хэрэгжүүлэх арга замын талаар ярилцжээ. Мөн үндэсний хэмжээнд жендэрээр ялгаварласан хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх ухуулга сурталчилгааны материалын цомог гаргаж, бага хуралд оролцогчдод тараасан байна.

Арабын орнуудын хүрээнд: НҮБ-ын Хүн амын сан Арабын эмэгтэйчүүдийн сургалт, судалгааны төвтэй түншлэн, ядуурлыг бууруулах стратеги, НҮЭМ ба эрхийг сурталчлах ажлыг дэмжих асуудлаар эмэгтэй удирдагчдыг бэлтгэж байна. Үндэсний ТББ-уудыг жендэрийн тэгш байдлын асуудлаар кампанит ажил явуулах бололцоогоор хангасан нь эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдалд хандах хариуцлагыг нэмэгдүүлжээ.

Уругвай: Энэ улсын Сенатын танхимын дэргэд саяхан Хүн ам, хөгжил, оролцооны асуудлаар Комисс байгуулсан байна. Хүн ам, хөгжлийн Олон улсын бага хуралд идэвхтэй оролцож байсан парламентын гишүүн анх санаачилжээ.

Монгол дахь жендэрийн тэгш байдал

Монголд жендэрийн харилцаа харьцангуй тэгш байдалтай боловч сүүлийн үеийн судалгааны дүн мэдээллээс үзэхэд шилжилтийн үр дагавар эрэгтэй, эмэгтэй хүмүүст ихээхэн ялгаатай тусдаг байна. Хүн амын амьжиргааны түвшинг оролцооны аргаар судалсан судалгааны мэдээллээс үзэхэд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүд ядууралд илүүтэй нэрвэгдэж байна. Тэгш бус байдал нь эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдах боломжийг хязгаарлаж, нийгмийн халамж хамгааллын хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах, гэр бүлийн хүчирхийллийг багасгах, хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлалыг арилгах, гэр бүлийн гишүүдийн дотоод харилцаа, шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдлыг хангах асуудалд илүүтэй анхаарал төвлөрүүлэх шаардлагатай байна.

Боловсрол: Боловсролын бүхий л салбарт суралцагчдын дунд охид давамгайлж, хөвгүүдийн сургуульд хамрагдалт хоцрогдсон хэвээр байна. БСШУЯ-ны тоо баримтаар дээд сургуулийн нийт оюутны 73 хувь, бакалаврын боловсрол эзэмших оюутнуудын 63 хувь, магистрын боловсрол эзэмших оюутнуудын 65 хувийг эмэгтэйчүүд тус тус эзэлж байна. Хөвгүүдийн сургууль завсардалт хотын ядуу, эмзэг бүлгийн гэр бүлийн дунд ангийн хүүхдийн дотор өндөр хувийн жинтэй, харин хөдөөд орлогын түвшингээс үл хамааран бага ангид түгээмэл үзэгдэж байна. Амьжиргааны түвшинг оролцооны аргаар судалсан судалгааны материалд

сургууль завсардалтын 42 хувь нь амьжиргааны боломж муутайгаас хөвгүүдийг өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажилд оролцуулах хэрэгцээнээс болсон гэж тайлбарлажээ. Хөдөөд хөвгүүдийн сургууль завсардалт хотынхоос хоёр дахин өндөр байна. Иймээс хөвгүүдийн сургууль завсардалтыг бууруулах бодлогын дорвитой арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эдийн засгийн боломж, бололцоо: Эмэгтэйчүүдийн ядуурал хот, хөдөөд түгээмэл байна. Сумын эмэгтэйчүүдийн 52 хувь ядуу зүдүү аж төрж байхад эрэгтэйчүүдийн 28 хувь нь ядуу байна. Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал судалгаагаар гэр бүлийн үл хөдлөх хөрөнгө, санхүүгийн томоохон бизнес, үнэ цэнэтэй зүйлийг худалдан авах, худалдах зэрэг үйл ажиллагаанд гэрийн эзэн зонхилж, харин өдөр тутмын хэрэглээний зүйлс худалдан авахад гэрийн эхнэр, эмэгтэйчүүд илүүтэй шийдвэр гаргах байдал давамгайлж байна. Эмэгтэйчүүдийн хөрөнгө захиран зарцуулах, өмч эзэмших, зээл авах зэрэг бие даасан эдийн засгийн үйл ажиллагаа харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна. Үүнтэй холбоотойгоор гэр бүлийн болон эдийн засгийн харилцаанд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн оролцох боломжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрх: Хүн амын НҮЭМ-ийн мэдлэг дээшилж, гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн арга хэрэгслийн хэрэглээ 1998 онд 33 хувь байсан бол 2003 онд 45 хувь болтлоо өсчээ. Эхчүүдийн амрах байрны үйлчилгээ сэргэж, оношлогоо эмчилгээнд шинэлэг арга барил нэвтэрч ирсэн нь эхийн эндэгдэл буурахад эерэгээр нөлөөлж байна. Эхийн эндэгдэл 2002 онд 100,000 амьд төрөлтөд 158 байсан бол 2004 онд 98.8 болж буурлаа. Гэвч жирэмслэлт, төрөлт, төрөлтийн дараах үеийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж жигд бус байгаа бөгөөд хот, хөдөөгийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний чанар зөрүүтэй хэвээр байна. БЗДХ нийт хүн амын дунд түгээмэл байгаа төдийгүй 1991-2002 онд 10,000 хүн амд ногдох тэмбүү 3,7 хувиас 6,7 хувь хүртэл, заг хүйтэн 9,4 хувиас 19,6 хувь хүртэл өсчээ. Биеэ үнэлэгчдийн тоо буурахгүй байгаа, шилжих хөдөлгөөнд эрэгтэйчүүд илүү оролцож байгаа, хүмүүсийн гадаадад албаны болон хувийн хэргээр аялах ажил нэмэгдсэн зэрэг олон хүчин зүйл ХДХВ\ДОХ-ын эрсдлийг нэмэгдүүлж байна. Зарим бүс нутагт эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд, түүний эрх уламжлалт хэвшмэл зан заншлаас үүдэлтэйгээр зөрчигдөж, эрүүл мэндэд нь эрсдэл учрах байдал үүссээр байна.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо: Хууль тогтоох байгууллагад сонгогдсон эмэгтэйчүүдийн төлөөлөл сүүлийн сонгуулиар мэдэгдэхүйц буурчээ. УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 2000 оны сонгуулиар 11,8 хувь байсан бол 2004 оны сонгуулиар 6,5 хувь болтол буурсан байна. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөлөл буурсан нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын салбарын хүрээнд жендэрийн тэгш бус байдал амь бөхтэй оршсоор байгааг харуулж байна. Шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш бус байдалд сонгуулийн нэр дэвшүүлэх тогтолцоо шударга бус, улс төрийн намуудын жендэрийн мэдрэмж сул, эрэгтэйчүүдийн хэвшмэл сэтгэлгээ давамгайлсан хэвээр байгаа зэрэг хүчин зүйл нөлөөлсөн байна.

Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүдийн оролцооны хувь харьцангуй өндөр байдаг хэдий ч улсын болон хувийн хэвшлийн байгууллагад эмэгтэйчүүд өндөр албан тушаалд ажиллах явдал доогуур байна. Энэ байдал нь төв, орон нутгийн бүх шатны байгууллагын боловсон хүчний бодлого, төсвийн хөрөнгийн төлөвлөлт,

хуваарилалтад жендэрийн мэдрэмжтэй хандахад сөргөөр нөлөөлж байна. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог ихээхэн нэмэгдүүлснээр төрийн бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, төслийн баримт бичгийг шинээр батлан гаргахад эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрийн тэгш байдлыг хангахад мэдэгдэхүйц ахиц дэвшилд хүрэх боломжтой болох юм.